



Хэвлэлийн хүүдас

Эдийн засгийн бодлогын хоёр дахь удаагийн чуулга уулзалт Монголын улсын банкны систем болон төсвийн санхүүгийн асуудлыг хэлэлцэх болно.

Дэлхийн банкны Ази номхон далайн бүсийн Ерөнхий эдийн засагч, Финлянд улсын Их хурлын гишүүн, Чили улсын Сангийн яамны олон улсын санхүү хариуцсан зөвлөх, Олон улсын валютын сан, Нидерландын Сангийн яамны төлөөлөгч нар Монголын улсын Их хурал болон Засгийн газрын гишүүд, нийгмийн бусад төлөөлөлтэй хамтран Монгол орны эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар ярилцана

Улаанбаатар, 2009 оны 10 сарын 26- Дэлхийн эдийн засгийн төлөөлөгчид энэ долоо хоногт нийслэл Улаанбаатар хотноо Монгол улсын эдийн засгийн одоогийн байдал болоод ирээдүйн чиг хандлагын талаар ярилцана.

Дэлхийн банкнаас Монголын Засгийн газартай хамтран олон улсын хэмжээнд санхүүгийн хямрал эхэлж байх үе буюу 2008 оны 10 сарын 28-нд Монголын эдийн засгийн бодлогын анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулсан билээ. Яг нэг жилийн дараа буюу 2009 оны 10 сарын 29-нд Монгол улсын эдийн засгийн бодлогын хоёрдугаар чуулга уулзалтыг Дэлхийн банкнаас зохион явуулах гэж байна.

Монголын эдийн засгийн бодлогын чуулга уулзалтын гол зорилго нь гадаад болон дотоодын бодлого тодорхойлогчдыг цуглуулан Монгол улсын хөгжилд тулгарч буй сорилтуудыг даван туулах арга замуудын талаар ярилцах. Хоёр дах удаагийн чуулга уулзалтын үндсэн сэдэв нь дэлхийг хамарсан эдийн засгийн хямралын нөлөөнд автаж буй Монгол улсын банкны систем болоод төсвийн санхүүгийн асуудал байна.

Чуулга уулзалтанд олон орны арвин туршлага, мэдлэг бүхий эдийн засагчид болон бодлого тодорхойлогч ч нар оролцоно. Үүнд Дэлхийн банкны Ази номхон далайн бүсийн Ерөнхий эдийн засагч, Финлянд улсын Их хурлын гишүүн, Чили улсын Сангийн яамны олон улсын санхүү хариуцсан зөвлөх, Олон улсын валютын сан, Нидерландын Сангийн яамны төлөөлөгч зэрэг хүмүүс байна. Тэдэнтэй хамт мөн Монгол улсын их хурал, засгийн газрын эрхэм гишүүд, гадаад түншүүд, иргэний нийгмийн төлөөлөл, академич нар санал солилцож сонирхолтой мэтгэлцээн явуулна



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж чуулга уулзалтыг нээж үг эхэлнэ. Чуулга уулзалт нь үр өгөөжтэй, зохистой санхүүгийн систем бүрдүүлэх, төсвийн хариуцлага гэсэн үндсэн хоёр сэдвийн хүрээнд олон улсын болон дотоодын илтгэгч нар харилцан туршлагаа хуваалцан, дэлхийн эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл дэх Монголын хөгжлийн боломжууд болон анхаарах асуудлуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ.

2008 оны 10 сарын 29-ны Пүрэв гаригт Соёлын төв өргөөнд болох энэхүү эдийн засгийн бодлогын чуулга уулзалтанд 1000 орчим хүмүүс оролцоно.

Чуулга уулзалтыг төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн мэдээллэх болно.

Чуулга уулзалтын мэдээллүүдийг www.worldbank.org.mn сайтад байрлуулна.

Уулзалтын үер сурвалжлага хийх талаар:

- Уулзалт хэвлэл мэдээллийхэнд нээлттэй болно. Та бүхэн уулзалтанд оролцох, сурвалжлага хийх талаар доорх хаягаар бүртгүүлэх шаардлагатай.
- 2009 оны 10 сарын 29-ны 10.30 д Хэвлэлийн бага хуралтай. Мөн тус өдрийн 15.30 цагт буюу цайны завсарлагаанаар олон улсын болон гадаадын илтгэгч нартай уулзаж ярилцлага хийх боломжтой.

Хэвлэл мэдээллийн өрөө Соёлын төв өргөөний нэг давхарт байрлах болно.

Харилцах хүмүүс:

Улаанбаатар дахь Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар

Ж.Сүнжидмаа

Утас: (976-11)312-647 дотуур утас. 207

Факс: (976 11) 312645

Гар утас: 9908 7912

Е-мэйл: sjamba@worldbank.org

Маяа Разат

Утас: (976-11)312-647 дотуур утас. 217

Гар утас: 99062905

Е-мэйл: mrizat@worldbank.org